



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/152

Мөрөн сум

Зөвлөлийг шинэчлэн байгуулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/200 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий аймгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: -Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын Дизайн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжил, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн

“Оюуны чадамж хөгжил” төрийн бус байгууллагын дэргэдэх Хөдөлмөрийн биржийн сургагч багш, ажил мэргэжил судлалын зөвлөх

“Оюуны чадамж хөгжил” төрийн бус байгууллагын дэргэдэх Хөдөлмөрийн биржийн зөвлөх

Ерөнхий боловсролын “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

Ерөнхий боловсролын Сод-Эрдэм сургуулийн багш

Политехник коллежийн нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

6717010574



2.


Политехник коллежийн нийгмийн ажилтан

Мөрөн сумын Насан туршийн боловсролын төвийн багш -2

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, шинжлэх ухааны бодлого үйл ажиллагаа зохион байгуулах ахлах мэргэжилтэн

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Зөвлөл байгуулах тухай” А/47 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан тайлагнаж ажиллахыг аймгийн Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН